

БАТЛАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ХОНГОРЗУЛ

Н.Хонгорзул

МАХНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЖ, ХУДАЛДАН БОРЛУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зорилго: Дорноговь аймгийн Сайншанд сумын хавар, зуны улирлын хүн амын махны хэрэгцээг хангах, махны хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх, үнийг тогтвортжуулах зорилгоор 100 тонноос доошгүй махны нөөц бүрдүүлэн, хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулж, борлуулсан махны килограмм тутамд мөнгөн урамшуулал олгох.

Ажлын тодорхойлолт: Махны нөөц бүрдүүлэх, худалдан борлуулахад тавих техникийн шаардлага, стандартын дагуу бэлтгэсэн махыг хадгалж, худалдан борлуулах буюу дараах нөхцөлийг хангасан байна.

Стандарт:

1	Үхрийн мах	-Чанарын шаардлага хангасан, ариун цэвэр, халдвартгүйтгэлийн шинжилгээнд хамрагдсанаас гадна гарал үүслийн бичигтэй байх -Бүтэн буюу өрөөл, гэдэс доторгүй -Зориулалтын хөргүүр, зооринд стандартын дагуу хадгалах -Гэрээт дэлгүүрт тухай бүр өөрийн тээврийн хэрэгслээр хүргэх
2	Хонины мах	-Чанарын шаардлага хангасан, ариун цэвэр, халдвартгүйтгэлийн шинжилгээнд хамрагдсанаас гадна гарал үүслийн бичигтэй байх -Гулуузаар, гэдэс доторгүй, 20 кг-аас доошгүй жинтэй байх -Зориулалтын хөргүүр, зооринд стандартын дагуу хадгалах -Гэрээт дэлгүүрт тухай бүр өөрийн тээврийн хэрэгслээр хүргэх
3	Ямааны мах	-Чанарын шаардлага хангасан, ариун цэвэр, халдвартгүйтгэлийн шинжилгээнд хамрагдсанаас гадна гарал үүслийн бичигтэй байх -Гулуузаар, гэдэс доторгүй, 20 кг-аас доошгүй жинтэй байх -Зориулалтын хөргүүр, зооринд стандартын дагуу хадгалах -Гэрээт дэлгүүрт тухай бүр өөрийн тээврийн хэрэгслээр хүргэх

2.1. Мах худалдаалах, нөөцлөн борлуулах чиглэлээр 3 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан байх

2.2.Хүнсний зориулалтын чанар стандартын шаардлага хангасан хөргүүр, зоорьтой байх

2.3. Зориулалтын чанар стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр түгээлт хийдэг байх

2.4. Орон нутгийн малчдаас нөөцийн мах бэлтгэлийн 40 хувийг бэлтгэх нөөц бололцоотой байх (гарал үүслийн бичгээр баталгаажна)

2.5. Зориулалтын мах хөрөөдөх, жижиглэх, савлах, вакумжуулах тоног төхөөрөмжтэй байх

2.6. Худалдаанд гаргах нөөцийн мах нь хүнсний зориулалтын уутанд 1-5 кг-аар савласан байх ба “Нөөцийн мах-Max сүүний анхдугаар аян” гэсэн хаяг шошготой байх

2.7. Нөөцийн мах худалдан борлуулах гэрээт цэг салбар нь Сайншанд сумын баг бүрт байх ба борлуулалтын цэг бүрийн гадна талд “Нөөцийн мах” гэсэн хаягыг байрлуулсан байх

2.8. Гэрээт борлуулалтын цэг, дэлгүүрүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан пос терминал машин, хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн цаастай байх ба нөөцийн мах борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид /худалдан авагчид/ олгодог байх

2.9. Нөөцийн махыг бэлтгэсэн болон хадгалж байгаа үеийн фото зүргийг ирүүлсэн байх

2.10. Нөөцийн мах худалдан борлуулах үнийн мэдээлэл

№	Махны төрөл	Хэмжээ, тн	Зарах үнэ, төг	Урамшуулал, төг	Нийт мөнгөн дүн, төг
1	2	3	4	5	6
1	Үхрийн мах (цул)	30	13.000	2.000	15.000
	Үхрийн мах (ястай)		10.000	2.000	12.000
2	Хонь	50	8.000	2.000	10.000
3	Ямаа	20	6.000	2.000	8.000

2.11. Нөөцөлсөн махыг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл дээрх үнээр худалдан борлуулна.

2.12. Нөөцийн махыг худалдан борлуулсан махны 1 кг тутамд 2.000 хүртэлх төгрөгийн урамшуулал олгоно.

2.13. Нөөцийн махыг 100 тонн бэлтгэсэн эсэхийг ажлын хэсэг акт үйлдэж баталгаажуулсаны дараа тендерийн санхүүжилтийг 100 хувь олгоно.

БОЛОВСРУУЛСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 Н.БЯМБ АЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.МӨНХ-ЭРДЭНЭ



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ХОНГОРЗУЛ

Н.Хонгорзул

**НӨӨЦИЙН МАХ БЭЛТГЭХ, БОРЛУУЛАХ,
АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

1. Мах бэлтгэх тогтсон сүлжээтэй 3-аас доошгүй жил энэ үйл ажиллагааг эрхэлсэн туршлагатай, мах бэлтгэх байр, тоног төхөөрөмж, хадгалах агуулахтай байх

2. Тухайн орон нутагт байрлалтай өөрийн эзэмшилийн хөргөлттэй зоорьтой байх

3. Махыг мөчлөх, жижиглэх, ангилж савлах цехтэй, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байх

4. Мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх

5. Мах борлуулах өөрийн болон гэрээт борлуулагчтай байх

6. Бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг Мал эмнэлгийн газрын итгэмжлэгдсэн лабораторит тогтмол баталгаажуулдаг байх

БОЛОВСРУУЛСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.Бямб Ацэцэг

ХЯНАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.Мөнх-Эрдэнэ